# BAYAR
PROPERTY DEVELOPMENT



# TERRAZZO ШАЛ

## OPTIMAL SLAB™

Монголдоо анхдагч болж өвөрмөц зутгамал бетонон, терраззо, полиуретан шалны өргөн сонголтыг манай компани танд санал болгож байна. Бүтээгдэхүүний бүтэц нь 100% Байгалийн гаралтай, хуурай эрдсийн агрегатууд, тусгай хувиргасан портланд цемент болон шингэн нэмэлтүүдээс бүрдэнэ.

Терраззо шал нь шинэ бетонон гадаргуу дээр хийгддэг бөгөөд бетонон зуурмаг ашиглан давхарга үүсгэх ба гадаргуугийн хатуулгийг сайжруулан элэгдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлдэг. Энэ технологийг ашигласанаар гадаргуу дахь тоос шороо, шохойн чулуулаг үүсгэх гэмтэх эрсдэлийг бууруулдаг уян чанартай учир үйлдвэр болон худалдааны салбарт түлхүү ашиглагддаг

## БАРИЛГЫН АЖЛЫН ХУВААРИЙГ ХУРДАСГАХ!

**Жишээ: Төслийн хэмжээ 9000m2, 4 ажилчид**




**Үрэлтэд Тэсвэртэй**
**Böhme (DIN EN 13813)**









**ДЕКО ТЕРРАЗЗО**



**ДЕКО ЦАГААН**



BAYAR PROPERTY DEVELOPMENT

# ШАЛНЫ ТӨРЛҮҮД

BAYAR PROPERTY DEVELOPMENT



## ТЕРРАЗЗО ШАЛ

Бүтээгдэхүүний бүтэц нь 100% Байгалийн гаралтай, хуурай эрдсийн агрегатууд, тусгай хувиргасан портланд цемент болон шингэн нэмэлтүүдээс бүрдэнэ.



## ЗАМ ТАЛБАЙ

Хүнд даацын өндөр тэсвэртэй, шүүр таталттай гадаргуу нь хальтиргааны эсрэг бороо цасны тогтоцгүй



## ХӨНГӨН БЕТОНОН ШАЛ

Үйлдвэр аж ахуйн зориулалттай хөнгөн бетонон шал, уналттай усны траптай шийдэл



## НЯГТ БЕТОНОН ШАЛ

Бетонон гадаргуугийн хатуулгийг сайжруулж элэгдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлсэн, өнгө үзэмжийн өргөн сонголттой

МАНАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЧИЛАЛ

WATER ABSORTION DIN 52617 DIN EN ISO 15148 PASSED — усанд тэсвэртэй

CERTIFIED ABRASION RESISTANCE BS EN 13892-4: 2002 PASSED — үрэлтэд тэсвэртэй

DECLARATION OF PERFORMANCE CE — эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй

ANTI-SLIP DIN 51131 VALUATION: SAFE CERTIFIED — Хальтирах аюулгүй

# ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ БОЛОН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ





BAYAR
PROPERTY DEVELOPMENT

# АЖЛЫН ЯВЦ

BAYAR PROPERTY DEVELOPMENT



## СЭНСЭН ӨНГӨЛГӨӨТЭЙ БЕТОНОН ШАЛ

Энэхүү зурган дээр харагдаж буй ажлын явц нь бетонон зуурмаг авсанаас хойш 32 цагийн дотор бүрэн хөнгөн хөл хөдөлгөөн үүсгэх боломжтой.

# БЕТОНОН ШАЛНЫ БАГЦ



## ЭНГИЙН

**Зардал хэмнэсэн шийдэл**

Бүрдэл : Бетон зуурмаг М350/зузаан 10см, арматур/шалны сээтэг
Технологи: 4 үе шаттай
Нэмэлт шингэн: гадаргуу хатууруулагч
Гялбааны түвшин: хагас толигор
Эцсийн үр дүн: тэгш, гөлгөр, тоос тогтохгүй, арчилгаа хялбар гадаргуу
Харагдах байдал: жижиг ширхэг нь харагдахуйц, хагас торгомсог толигор



## ӨВӨРМӨЦ

**Гялалзсан, байгалийн үзэмжтэй**

Бүрдэл : Бетон зуурмаг М350/зузаан 10см, арматур/шалны сээтэг
Технологи: 5 үе шаттай
Нэмэлт шингэн: гадаргуу хатууруулагч/ суурь хамгаалагч
Гялбааны түвшин: гүн
Эцсийн үр дүн: тэгш, гялгар, тоос тогтохгүй, арчилгаа хялбар гадаргуу
Харагдах байдал: байгалийн мэт үзэсгэлэнтэй гүн өндөр гялалзсан гадаргуу



## ТАНСАГ

Шалны хамгийн дээд зэрэглэлийн тансаг байдал бий болгох

Бүрдэл : Бетон зуурмаг М350/зузаан 10см, арматур/шалны сээтэг
Технологи: 7 үе шаттай
Нэмэлт шингэн: гадаргуу хатууруулагч/ хамгаалах түрхэлгээ
Гялбааны түвшин: өндөр толигор ба гүн толигор
Эцсийн үр дүн: тэгш, гялгар, тоос тогтохгүй, арчилгаа хялбар гадаргуу
Харагдах байдал: жижиг ширхэг нь харагдахуйц, гүн толигор торгомсог

МАНАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЧИЛАЛ

DIN 52617 DIN EN ISO 15148 — усанд тэсвэртэй

ABRASION RESISTANCE BS EN 13892-4: 2002 — үрэлтэд тэсвэртэй

CE — эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй

DIN 51131 VALUATION:SAFE — Хальтирах аюулгүй

www.bpd.mn
9988-8217

# UCRETE ШАЛ

## UCRETE - 1969 ОНООС ХОЙШ ДЭЛХИЙН ХАМГИЙН БАТ БЭХ ШАЛ

### 50 гаруй жилийн турш хамгийн өндөр түвшинд ажиллаж буй шал:

Шинэлэг, найдвартай,үр ашигтай энгийн шийдлүүд нь Ucrete шалны нэр төрлийг хөгжүүлэхэд гол хүчин зүйл болдог. Хэрэв та өөрийн шаардлагад төгс нийцэх шал хайж байгаа бол Ucrete нь хүнс, шингэн хүнс, эм зүй, хими, түүхий эд боловсруулах болон хүнд аж үйлдвэрлэлийн орчинд олон арван жилийн турш шалгагдаж ирсэн найдвартай үзүүлэлттэй, баталгаатай, нэр хүнд бүхий шал юм.




## ГОЛ ДАВУУ ТАЛУУД

Ucrete аж үйлдвэрлэлийн зориулалттай шал нь зах зээлд маш бат бэх, цэвэрхэн, хүнд даацын полиуритан шалны дээд жишгийг тогтоож өгсөн юм.

Аюулгүй байдал, гүйцэтгэлийн хувьд орчин үеийн боловсруулах аж үйлдвэрлэлийн бүхий л хэрэгцээг хангаж, суурилуулахад хялбар, хурдан бөгөөд бодит байдал дээр тохирсон байдаг нь хэрэглэгчдэд үнэ цэнэтэй үр ашгийг өгч чаддаг.

Энэхүү бүтээгдэхүүнд нь хүнс болон шингэн хүнсний үйлдвэр, эм зүй, химийн болон хүнд аж үйлдвэрлэлийн салбарт 50 гаруй жилийн турш ашиглагдаж ирсэн, гүйцэтгэлийн хувьд харьцуулшгүй нэр хүнд бүхий бүтээгдэхүүнүүдийн нийлмэл багц юм.

Ucrete шалны урт удаан эдэлгээ нь үйлдвэрлэлийн сул зогсолтын хугацааг багасгах аюулгүй, эрүүл ахуйд нийцсэн, үр ашигтай ажиллах орчныг бүрдүүлдэг бөгөөд энэ нь хамгийн зардал хэмнэсэн шийдэл болж чадсан юм.

**Урт хугацааны эдэлгээ даах чанар**

20-30 жилийн насжилттай Ucrete шал нь үйлдвэрлэлийн бүхий л орчинд одоог хүртэл найдвартай хэрэглэгдсээр байна.

**Цэвэр бас аюулгүй**

Eurofins-ийн Дотоод орчны Агаарын Тохирлын Алтай стандартын дагуу гэрчилгээжсэн. Үүгээрээ таны ажлын орчин, ажиллагсад, бараа бүтээгдэхүүний цэвэр, аюулгүй байдлыг айдвартай бий болгоно.

**Эрүүл ахуй**

Зэвэрдэггүй гантай ижил стандартын дагуу буюу нян бактери үрждэггүй технологиор хийгдсэн нь эрүүл ахуйн стандартыг дээд зэргээр хангадаг

**Үнэргүй**

Хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харьцаж ажиллах газарт ч мөн ашиглах боломжтой

**Химийн бодисын үйлчлэлд тэсвэртэй**

Бусад төрлийн резинэн шалыг хурдан түлж гэмтээдэг хүчтэй хүчил, шүлт, өөх тос, газрын тос, уусгагч зэрэг химийн бодисуудыг Ucrete шал нь тэсвэрлэх чадвартай.

**Хурдан суурилуулалт болон бэхжилт**

Хүйтэн температурт ч шалны хучилт хийхэд тохиромжтой. Шаланд хучилт хийснээс хойш 10°C температурт ердөө 5 цагийн дараа маш хурдан бэхжиж, үйл ажиллагаа явуулахад бэлэн болох боломжтой.

**Температурын хэт үйлчлэлд тэсвэртэй**

Техникийн үзүүлэлтээс хамааран +150°C хүртэл шингэний гоожилт/ асгаралтад тэсвэртэй

**Урт хугацааны эдэлгээ даах чанар**

Өнгө алдаж толбо тогтохгүй



## Таны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь

50 гаруй жилийн туршид бид хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төрөл бүрийн өнгө үзэмж болон техникийн үзүүлэлт бүхий өндөр гүйцэтгэлтэй, удаан эдэлгээтэй шалыг нийлүүлэх зорилгоор техникийн мэргэшсэн байдал, мэдлэг, зах зээлийг танин мэдэх зэрэгт хөрөнгө оруулалт хийсээр ирсэн билээ. Энэхүү товхимол танилцуулгын зорилго нь одоо болон ирээдүйд таны хэрэгцээ шаардлагад нийцсэн хамгийн сайн чанартай шалыг сонгоход тань туслах юм

**Цэвэр бас аюулгүй**

Ucrete шал нь аж үйлдвэрлэлийн зориулалттай шал боловч энэ нь тухайн шал эв хавгүй, үзэмж муутай байх ёстой гэсэн үг биш. Өнгө будаг нь тогтвортой, химийн бодис, халуун хүйтний цочрол болон механик хүчин зүйлд өртөх үед цэвэрлэхэд хялбар, химийн бодист тэсвэртэй чанар зэрэг нь дэлхийн олон оронд Ucrete шалны нэр хүндийг бий болгосон юм.

**Халтирахгүй**

Тухайн шал суурилуулах газрын хэрэгцээ буюу шингэн асгаралт хэр их байх, тухайн газарт явагдаж буй ажлын төрөл,хийгдэх үйлчилгээний ажил, цэвэрлэгээний стандарт зэргээс хамааран хамгийн тохиромжтой гадаргуут сонгон суурилуулах болно. Халтирахаас сэргийлдэг давуу талын талаар 10-р хуудаснаас авч үзнэ үү

**Халуун, хүйтэн хэмд тэсвэртэй**

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах температураас нь хамааран шалны шаардлагатай зузааныг тодорхойлох бөгөөд хамгийн тохиромжтой хэмжээг тогтоож өгнө. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 8-р хуудаснаас авч үзнэ үү.

**Цахилгаан дамжуулдаггүй**

Цахилгаан цэнэгт амархан өртдөг төхөөрөмжийг цэнэгжихээс хамгаалан, эвдрэх эрсдэлийг бууруулдаг. Цахилгаан дамжуулдаггүй төрөл бүрийн шалны дэлгэрэнгүй мэдээллийг 14-р хуудаснаас авах боломжтой.

**Химийн идэмхий бодист тэсвэртэй**

Бүх Ucrete шалнууд нь 12-р хуудаст хүснэгтэд харуулсан химийн хортой бодист тэсвэртэй.

**Суурилуулахад хурдан**

Үйлдвэрлэлийн явцыг зогсоох нь байгууллагуудын хувьд тийм ч сайн зүйл биш гэдгийг бид мэддэг тул манай шалны иханх системийг амралтын өдрүүдэд эсвэл бүр шөнийн цагаар ч суурилуулах боломжтой. Ажлын сул зогсолтын хугацааг багасгах замаар бид Ucrete шалны зардлыг бууруулсан. Жишээлбэл: Ucrete UD200 шал суулгаснаас хойш 10°C градуст ердөө 5 цагийн дараа бүрэн бэхжиж ашиглалтанд бэлэн болно

**Цохилтод тэсвэртэй**

Хүнд даацийн машин механизм ажилладаг, хүчтэй том дугуйгаар тухайн талбайд явах тохиолдолд илүү том ширхэгтэй, нягт өндөртэй дүүргэгч бүхий системийг ашиглах шаардлагатай.

**Урьдчилан ярилцах шийдэл**

Таны бүх хэрэгцээ шаардлагыг хангах шал сонгохын тулд олон төрлийн Ucrete шалнаас аль тохирохыг тодорхойлон, бид тантай урьдчилан зөвлөлдөх болно. Бид танай үйлдвэр, байгууламжид тохирсон хамгийн чанартай, хамгийн хэмнэлттэй шалны шийдлийг сонгоход туслан та бүхэнтэй хамтран ажиллах болно

**Үнэргүй**

Ucrete шалны систем нь хэрэглээний явцад өнгө, чанараа алддаггүй тул дахин засварын ажлын үед ч аюулгүй сонголт болж өгдөг.

**Эрүүл ахуй**

Ucrete шал нь нян бактери үржихээс сэргийлсэн бүтэцтэй бөгөөд зэвэрдэггүй гангийн адил цэвэрлэхэд хялбар. Дэлгэрэнгүй мэдээллийг 1 6-р хуудаснаас авч үзнэ үү